

МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЧЛОЛ

№ 17/2

Улаанбаатар хот

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл (МБЗ) 2017 оны 6 дугаар сарын 15-ны өдөр хуралдаж, хурлыг Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан удирдав.

МБЗ-ийн хурлаар Монголбанкны Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас гадаад эдийн засгийн орчин, макро эдийн засгийн өнөөгийн болон ойрын ирээдүйн төлөв, бодлогын хувилбарууд бүхий дунд хугацааны төсөөлөл, мөнгөний бодлогын саналыг танилцуулав.

Эдийн засгийн өсөлт харьцангуй өндөр гарч, хувийн хэрэглээ өсч, гадаад орчин сайжирч, богино хугацааны гадаад төлбөрийн дарамт буурч, төгрөгийн өгөөж нэмэгдэж байгаа зэрэг нь эдийн засагт сэргэлт ажиглагдаж байгааг дохиолж байна. Тухайлбал, эдийн засгийн өсөлт 2016 оны эхний гурван улиралд -1.6 хувь байсан бол 2016 оны 4 дүгээр улиралд 7.8 хувь, 2017 оны 1 дүгээр улиралд 4.2 хувьд хүрлээ. Эдийн засгийн өсөлтөд уул уурхайн бус салбарууд, үүн дотроо бүтээгдэхүүний цэвэр татвар, худалдааны салбарын өсөлт хүлээж байснаас сайжирсан, гадаад худалдааны нөхцөл сайжирсан, хөрөнгө оруулалт нэмэгдсэн нь эерэг нөлөө үзүүлэв. Эрэлт талаас уул уурхайн салбарын бүтээн байгуулалттай холбоотойгоор хөрөнгө оруулалт нэмэгдсэн нь нөлөөлөв. Эдийн засагт одоогоор уул уурхай, түүний бүтээн байгуулалттай холбоотой өсөлт бий болж, харин уул уурхайгаас хамаарал багатай эдийн засгийн салбаруудын идэвхжил сул хэвээр байна. Хөдөлмөрийн зах зээл дээр ч мөн адил уул уурхайн бүтээн байгуулалттай холбоотой салбаруудад голчлон ажил эрхлэлт нэмэгдэж байна.

Монгол улсын гадаад эрэлт 2017 оны эхний хагас жилд сайжирсан ч цаашид буурах хандлага үргэлжлэхээр байна. Хэдийгээр БНХАУ-ын Засгийн газраас төсвийн зөөлөн бодлого хэрэгжүүлэн эдийн засгаа тэтгэж, 2017 оны I улиралд хүлээлтээс давж 6.9 хувиар өссөн ч хувийн секторын өр өндөр хэвээр, үл хөдлөх хөрөнгийн салбар нь саарч байгаагаас тус эдийн засгийн өсөлтийн буурах тренд үргэлжлэх болгоомжлол байсаар байна. Харин Евро бүсийн эдийн засгийн өсөлт тогтвортой байх, газрын тосны үнэ сэргэх нөлөөгөөр ОХУ-ын эдийн засаг алгуур өсөх төлөвтэй байгаа нь манай гадаад эрэлтэд эерэгээр нөлөөлнө.

2017 оны I улиралд экспортын үнэ өсч, худалдааны нөхцөл хүлээж байснаас сайжирлаа. Өмнөх төсөөлөлтэй харьцуулахад 2017 онд зэс, алтны үнэ нэмэгдэх, нүүрс, төмрийн хүдрийн үнэ буурах, газрын тосны үнэ төдийлөн өөрчлөгдөхөөргүй байна. 2017 оны 1 дүгээр улиралд урсгал болон хөрөнгийн данс 157.0 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 105.9 сая ам.долларын ашигтай гарч, улмаар нийт тэнцэл 163.7 сая ам.долларын алдагдалтай гарсан. Цаашид ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд донор орон, олон улсын байгууллагуудын

санхүүжилт болон уул уурхайн бүтээн байгуулалттай холбоотойгоор гадаадын шууд хөрөнгө оруулалт тус тус нэмэгдэн төлбөрийн тэнцэл сайжрах төлөвтэй байна.

Инфляци 2017 оны 5 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд жилийн 3.7 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд жилийн 3.8 хувьд хүрээд байна. Суурь төсөөллөөр инфляци цаашид алгуур өсөх хандлагатай байгаа бөгөөд үүнд эдийн засгийн сэргэлттэй уялдан эрэлтийн шинжтэй хүчин зүйлс, мөн нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйлс, зарим төрлийн татвар нэмэгдэх нь нөлөөлж байна. Үндэсний статистикийн хорооноос өргөн хэрэглээний барааны сагсыг шинэчилж, шинэ бараанууд орж ирсэн нь 1 орчим хувийн инфляцийн өсөлтийг бий болгож байна. Инфляци 2018 оны дунд хүртэл өсөх хэдий ч 2019 онд одоогийн зорилтот түвшний орчимд тогтворжих төлөвтэй байна.

Өнгөрсөн оны сүүлийн хагасаас хэрэгжүүлсэн мөнгө, төсвийн бодлогын арга хэмжээ болон ОУВС-гийн хөтөлбөр хэрэгжих шийдвэр батлагдсан зэрэг нь богино хугацааны эрсдлийг бууруулж, эдийн засгийн төлөвийн талаарх зах зээл дээрх эерэг хүлээлтийг бий болгож байна. Нөгөө талаас экспортын үнэ, гадаад худалдааны нөхцөл сайжран, гадаад валютын орох урсгал, хүлээлтэд эерэгээр нөлөөлж байна. Эдгээрийн нөлөөгөөр төгрөгийн ханш чангарч, 2017 оны эхний улиралд төгрөгийн харьцангуй өгөөж нэмэгдлээ. Иймээс өнгөрсөн онд санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор бодлогын хүүг нэмэгдүүлсэн бодлогын арга хэмжээг зөөлрүүлэх нөхцөл бүрдэж байна.

Цаашид зах зээлд эерэг хүлээлт үргэлжлэх тохиолдолд өгөөж хайсан, богино хугацаатай хөрөнгийн дотогшлох урсгалыг бий болгож болзошгүй байгаа нь валютын ханш чангарах дарамтыг өдөөх, зээлийн долларжилт нэмэгдэх, мөнгө, зээлийн өсөлт хурдсах зэргээр санхүүгийн секторт эрсдэл хуримтлагдах, инфляци эрчимжих нөлөө илрэх зэргээр мөнгөний бодлогод сорилт болж болзошгүй юм. Тухайлбал, өгөөж хайсан, богино хугацаат хөрөнгийн дотогшлох урсгалыг нэмэгдүүлж, төгрөгийн ханш чангарах дарамт өсөх, энэ нь уул уурхайгаас хамаарал багатай эдийн засгийн салбаруудын өрсөлдөх чадварыг муутгаж болзошгүй. Хөрөнгийн урсгалыг даган зээлийн долларжилт нэмэгдэх, мөнгө, зээлийн өсөлт хурдсах зэргээр эдийн засагт хэт халалт үүсч, улмаар инфляци эрчимжиж, ханшийн болон хугацааны зөрүүтэй байдал үүсэх, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдаж болзошгүй.

МБГ-ын зүгээс эдийн засгийн дотоод болон гадаад нөхцөл, төсөв, мөнгөний бодлогын төлөвт үндэслэн мөнгөний бодлогын төлөвийг зөөлрүүлж, бодлогын хүүг 2 нэгж хувиар бууруулах, Мөнгөний бодлогын “хүүгийн коридор” системийг Монголбанкны бодлогын хүүгийн хувь хэмжээнээс +2, -2 нэгж хувийн өргөнөөр тэгш хэмтэйгээр шинэчлэн тогтоох саналыг дэвшүүлэв. Бодлогын хүүг бууруулах саналын гол үндэслэл нь суурь төсөөллөөр эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамт бага байгаа, өсөлт сэргэсэн ч уул уурхайн салбараас хамаарал багатай эдийн засгийн салбаруудын идэвхижил сул хэвээр, төгрөгийн ханш чангарах чиглэлд өөрчлөгдсөн, төсвийн бодлогын өнөөгийн төлөв мөнгөний бодлогыг зөөлрүүлэх орон зайг бий болгосон зэрэг гэж үзлээ. Бодлогын “хүүгийн коридор”-ийг тэгш хэмтэй болгох нь нэгд; мөнгөний бодлогын төлөвийг чангаруулж, банк хоорондын захын хүүг бодлогын хүүтэй ойролцоо авчирснаар

бодлогын хүүний дохиог илүү хүчтэй өгөх, хоёрт; зах зээлийн нөхцөл байдал өөрчлөгдөж, төгрөгийн ханш чангарах чиглэлд өөрчлөгдсөн энэ үед өндөр өгөөжтэй 84 хоногийн ТБҮЦ арилжаалах шаардлагагүй болсон зэрэгтэй холбоотой.

МБЗ-ийн хурлаар МБГ-аас оруулсан саналд гишүүд нэмэлт тодруулга авах, бодлогын сорилтуудыг хэлэлцэх, саналыг дэмжих хэлбэрээр өрнөлөө. МБЗ-ийн гишүүд мөнгөний нийлүүлэлт болон үйлдвэрлэлийн зөрүүний төсөөлөл, төгрөгийн ханшийг хэрхэн тогтворжуулах талаар, зээлийн эрсдэл түүний өсөлтийг хэрхэн зохистой түвшинд барих, заавал байлгах нөөцөд тооцох урамшууллыг өөрчлөх эсэх талаар тодруулан хэлэлцэв.

МБЗ-ийн нийт гишүүд Мөнгөний бодлогын хүүг бууруулах шийдвэрийг дэмжсэн байр суурьтай байв. Гишүүд хүүг бууруулах үндэслэлүүдийг дэмжиж, ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд зарим татвар нэмэх, төсвийн төлөвийг чангаруулах зохицуулалтыг ирэх жилүүдэд хийхээр байгаа нь мөнгөний бодлогын төлөвийг сулруулах орон зайг олгож байгааг онцолж байв.

МБЗ-ийн гишүүдийн дийлэнх нь Мөнгөний бодлогын “хүүгийн коридор” системийг тэгш хэмтэй болгох саналыг дэмжсэн ч, зарим гишүүд дэмжихгүй саналтай байв. Энэ нь мөнгөний бодлогын төлөвийг хэт зөөлрүүлснээр инфляци хүлээлтээсээ давж гарах эрсдэлтэй гэж үзсэнтэй холбоотой.

Ийнхүү МБЗ-ийн гишүүд мөнгөний бодлогын төлөвийг сулруулах санал, түүний эдийн засагт үзүүлэх нөлөөллийг хэлэлцсэний дараа Мөнгөний бодлогын хүүг 2 нэгж хувиар бууруулах, бодлогын “хүүгийн коридор” системийг тэгш хэмтэй болгох томъёоллоор санал хураахад МБЗ-ийн гишүүд 100% саналыг дэмжиж, үдээс хойш хэвлэлийн хурлаар олон нийтэд мэдээлэхээр тогтсоноор МБЗ-ийн хурал өндөрлөв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголбанкны МБЗ-ийн 2017 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар Бодлогын хүүг 2017 оны 6 дугаар сард 2 нэгж хувиар бууруулж 12 хувьд хүргэх, Мөнгөний бодлогын “хүүгийн коридор” системийг Монголбанкны бодлогын хүүгийн хувь хэмжээнээс +2, -2 нэгж хувийн өргөнөөр тэгш хэмтэйгээр шинэчлэн тогтоох шийдвэр гаргасан.